
ВИДЕО ШТОРК · 2023 оны 3-р сарын 27

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ СУДАЛЛАА



Баян-Өлгий аймгийн прокурорын газраас тус аймагт үйлдэгдсэн Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн гаралт, шалтгаан нөхцөлийг 2022 оны байдлаар судлахад сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа нь тогтоогджээ.

Тодруулбал, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн хэрэг 2022 онд 291 бүртгэгдсэн нь нийт зөрчлийн хэргийн 40.4 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь 2021 онтой харьцуулахад 42,6 хувиар өссөн дүнтэй гарсан байна.



Харин Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2020 онд шалгаж шийдвэрлэсэн нийт гэмт хэргийн 9.9 хувь, 2021 онд 5.7 хувь, 2022 онд 4.3 хувийг эзэлж байгаа нь нийт гэмт хэрэгтэй харьцуулахад тодорхой хувиар буурсан боловч бүртгэгдсэн хэргийн тоо буураагүй, адил түвшинд байгаа болох нь судалгаагаар тогтоогджээ.

Тиймээс аймгийн прокурорын газраас гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн шат дараалсан ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн байна.

Видео: https://www.youtube.com/watch?v=zcefzvOf7W8

Видео: https://www.youtube.com/watch?v=Nm3mOqinEh0

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1774